ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр Дугаар А/07 Улаанбаатар хот

Хяналт шалгалтын удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.5, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай" 184 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төр, захиргааны барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг нэгдүгээр, "Худалдаа, олон нийт, үзвэр үйлчилгээний газрын барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг хоёрдугаар, Орон сууцны барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг гуравдугаар, "Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис ашигладаг иргэн хуулийн этгээдийн үйлдвэр агуулах"-д хяналт шалгалт хийх удирдамжийг дөрөвдүгээр, "Эрчим хүчний барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг тавдугаар, "Ил, далд уурхай, ашигт малтмалын боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг зургаадугаар, "Рашаан, сувилал, амралтын газрын барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг долоодугаар, "Газрын тос, хийн агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламж"-д хяналт шалгалт хийх удирдамжийг наймдугаар, "Эрүүл мэндийн байгууллага"-д хяналт шалгалт хийх удирдамжийг есдүгээр, "Хяналт шалгалт хийсэн мэдээний хүснэгт"-ийг аравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажиллагааны удирдлагын газар (хурандаа А.Дашням), Гал түймэртэй тэмцэх газар (хурандаа Ц.Нямбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

1426010111

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны ..09.. дугаар сарын ..09.... ны өдрийн
А/07..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

№ 2026-001-01

# ТӨР, ЗАХИРГААНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

## Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

## Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

**Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж**

3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төр, захиргааны зориулалттай барилга байгууламжийг хамруулна.

**Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 23-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт илгээнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

### Тав. Хариуцлага

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

9021120486
9129146 СБТ17150

№ 2026-001-02

# ХУДАЛДАА, ОЛОН НИЙТ, ҮЗВЭР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

## Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан "Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө", Хяналт шалгалт хийх нийтлэг журам, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад баримт бичиг нь тус хяналт, шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

## Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, гамшгаас хамгаалах хууль, холбогдох дүрэм, журам, стандарт болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн аюул, осол гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагааг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох хэлбэрээр арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд худалдаа, олон нийт, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг хамруулна.

## Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/236 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалт хийсэн илтгэх хуудас бичих загвар”-ын дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн disaster_inspector@nema.gov.mn цахим хаягт ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Ажиллагааны удирдлагын газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

## Тав. Хариуцлага

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулаагүй болон удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан тохиолдолд холбогдох гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, тухайн газар, хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---оОо---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/107 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

№ 2026-001-03

# ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

## Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

## Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд байгаа дунд төвөгшилтэй орон сууцны барилга байгууламжийг хамруулна.

## Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

## Тав. Хариуцлага

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 07 ны өдрийн
А/07 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

№ 2026-001-04

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЭЛ, ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС АШИГЛАДАГ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛДВЭР, АГУУЛАХАД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл**

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө”, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад баримт бичиг нь тус хяналт, шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

**Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр**

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, гамшгаас хамгаалах хууль, холбогдох дүрэм, журам, стандарт болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн аюул, осол гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагааг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох хэлбэрээр арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. улсын хэмжээнд үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис ашигладаг иргэн, хуулийн этгээдийн үйлдвэр, агуулахуудыг хамруулна.

## Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 09-30-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/236 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хяналт шалгалт хийсэн илтгэх хуудас бичих загвар"-ын дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн disaster_inspector@nema.gov.mn цахим хаягт илгээнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Ажиллагааны удирдлагын газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

## Тав. Хариуцлага

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулаагүй болон удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан тохиолдолд холбогдох гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, тухайн газар, хэлтсийн даргад хариуцлага тооцно

--oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/07 дугаар тушаалын тавдугаар хавсралт

№ 2026-001-05

ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ
БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл**

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

**Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр**

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрчим хүчний барилга байгууламжийг хамруулна.

## Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

## Тав. Хариуцлага

5.1. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 07 ны өдрийн
А/07 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

№ 2026-001-06

ИЛ, ДАЛД УУРХАЙ, АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ, ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл**

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө”, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад баримт бичиг нь тус хяналт, шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

**Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр**

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, гамшгаас хамгаалах хууль, холбогдох дүрэм, журам, стандарт болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн аюул, осол гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагааг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох хэлбэрээр арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ил, далд уухай, ашигт малтмалын боловсруулах үйлдвэрийн барилга байгууламжийг хамруулна.

## Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 07 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/236 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалт хийсэн илтгэх хуудас бичих загвар”-ын дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нар Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн disaster_inspector@nema.gov.mn цахим хаягт, Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт тус тус илгээнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Ажиллагааны удирдлагын газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

**Тав. Хариуцлага**

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулаагүй болон удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан тохиолдолд холбогдох гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, тухайн газар, хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/07 дугаар тушаалын долоодугаар хавсралт

№ 2026-001-07

# РАШААН, СУВИЛАЛ, АМРАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

## Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

## Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

**Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж**

3.1. Улсын хэмжээнд рашаан, сувилал, амралтын газрын үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг хамруулна.

**Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2025 оны 08 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 28-ний өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

**Тав. Хариуцлага**

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/07 дугаар тушаалын наймдугаар хавсралт

№ 2026-001-08

ГАЗРЫН ТОС, ХИЙН АГУУЛАХ, ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл**

1.1. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж гал түймрийн эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

**Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр**

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга хариуцна.

### Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд газрын тос, хийн агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламжийг хамруулна.

### Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан илтгэх хуудасны хамт Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн inspector.obeg@gmail.com цахим хаягт, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нар Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн disaster_inspector@nema.gov.mn цахим хаягт тус тус ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

## Тав. Хариуцлага

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан гал түймрийн улсын хяналтын байцаагч, тухайн газар хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---o0o---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дугаар сарын 09 ны өдрийн
А/07 дугаар тушаалын есдүгээр хавсралт

№ 2026-001-09

# ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

## Нэг. Хяналт шалгалтын зорилго, үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө”, Хяналт шалгалт хийх нийтлэг журам, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм болон холбогдох бусад баримт бичиг нь тус хяналт, шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

## Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

2.1. Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, гамшгаас хамгаалах хууль, холбогдох дүрэм, журам, стандарт болон энэхүү удирдамжийг баримтлан зохион байгуулна.

2.2. Хяналт шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтны хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

2.3. Хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт гэсэн 2 төрлийн хүрээнд зохион байгуулна.

2.4. Эрх бүхий албан тушаалтан нь хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.5. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулж байгаа болон учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн аюул, осол гарч болох тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулалгүйгээр тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үйл ажиллагааг бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох хэлбэрээр арга хэмжээ авна.

2.6. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

2.7. Шалгалтад хамрагдах объектын судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан удирдамжид заагдсан хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.

2.8. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулахдаа төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 80 хувийг заавал арилгуулж гүйцэтгэлийн хяналт шалгалтын илтгэх хуудсанд төлөвлөгөөт хяналт шалгалттай харьцуулсан дүнгээр тусгасан байна.

2.9. Хяналт шалгалт хийх нөхцөл, шаардлагатай зардлыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс хариуцна.

## Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах иргэн, хуулийн этгээд, барилга байгууламж

3.1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулна.

**Дөрөв. Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

| | |
|---|---|
| 4.1. Улсын хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.2. Нийслэлийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч; |
| Гишүүд | Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар; |
| 4.3. Орон нутгийн хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч | Төв орон нутгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, сумын Онцгой байдлын хэлтсийн дарга нар; |
| Гишүүд | Төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, байцаагч нар. |

4.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 10 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2026 оны 11 дүгээр сарын 01-20-ны өдрийг хүртэл хугацаанд тус тус зохион байгуулна.

4.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 10 дүгээр сарын 12-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2026 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны А/236 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хяналт шалгалт хийсэн илтгэх хуудас бичих загвар”-ын дагуу боловсруулж, зөрчлийг гэрэл зургаар баримтжуулан Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын хэлтсийн disaster_inspector@nema.gov.mn цахим хаягт ирүүлнэ.

4.6. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Ажиллагааны удирдлагын газар нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулна.

**Тав. Хариуцлага**

5.1.Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулаагүй болон удирдамжид заагдсан хугацаанд үр дүнгүй зохион байгуулсан тохиолдолд холбогдох гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, тухайн газар, хэлтсийн даргад хариуцлага тооцно.

---oOo---

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
А/07 дугаар тушаалын 10 дугаар хавсралт

# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ

Хүснэгт 1

| № | Аймгийн нэр | Хяналт шалгалтад хамрагдвал зохих объектын тоо | Хамрагдсан объектын тоо | Илрүүлсэн зөрчлийн тоо | Газар дээр нь арилгуулсан зөрчлийн тоо | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | | | | | Нээсэн зөрчлийн хэргийн тоо | Эрх хязгаарласан тоо | Торгуулийн шийтгэл /төгрөгөөр/ | | | | Тактикийн дадлага, сургалтын тоо | Тархалтын дадлага, сургалтын тоо | Олон нийтэд хүргэсэн хэвлэл мэдээллийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Албан шаардлага | Мэдэгдэл | Танилцуулга | Үйл ажиллагаа зогсоосон акт | Зөвлөмж | | | Хуулийн этгээдийн тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ | Иргэний тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ | | | |
| 1 | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | | | | | |

Жич: Батлагдсан удирдамжид тактик, тархалтын дадлага, сургалт зохион байгуулахаар тусгаагүй бол тактик, тархалтын дадлага сургалт гэсэн хүснэгтийг хоосон үлдээж болно.

ТАНИЛЦСАН
..................... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
............................... ................................../................................/
/цол/ /гарын үсэг/

МЭДЭЭ НЭГТГЭСЭН.
..................... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГТУХБ,
............................... ................................../................................/
/цол/ /гарын үсэг/

**........................................................ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД**
**ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН**
**МЭДЭЭНИЙ ХҮСНЭГТ**

Хүснэгт 2

| № | Аймгийн нэр | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | Төлөвлөгөөт хяналт шалгалтаар хүргүүлсэн баримт бичгийн тоо | | | Гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо | Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн зөрчлийн тоо | Баримт бичгийн хүрээнд арилгасан зөрчлийн тоо | Арилгуулсан зөрчлийн хувь | Нээсэн зөрчлийн хэргийн тоо | Хялбаршуулсан зөрчлийн хэргийн тоо | Эрх хязгаарласан тоо | Торгуулийн шийтгэл /төгрөгөөр/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | Мэдэгдэл | Үйл ажиллагаа зогсоосон акт | | | | | | | | Хуулийн этгээдийн тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ | Иргэний тоо | Торгуулийн хэмжээ /төгрөгөөр/ |
| 1 | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | | |

ТАНИЛЦСАН
..................... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
............................... ................................./................................./
*/цол/* *\/гарын үсэг/*

МЭДЭЭ НЭГТГЭСЭН.
..................... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГТУХБ,
............................... ................................./................................./
*/цол/* */гарын үсэг/*

---oOo---

БАТЛАВ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

| № | Хамрагдах байгууллага, барилга байгууламж | Хугацаа | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар |
| Төлөвлөгөөт хяналт шалгалт | | | | | | | | | | | | | |
| 1 | Үзвэр үйлчилгээ, худалдаа, олон нийтийн барилга байгууламж | 01.05<br>01.25 | 02.16 | 03.08 | | | | | | | | | |
| 2 | Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис ашигладаг иргэн, хуулийн этгээдийн үйлдвэр, агуулах | | | 03.09<br>03.30 | 04.21 | 05.11 | | | | | | | |
| 3 | Ил, далд уурхай, ашигт малтмалын баяжуулах, боловсруулах үйлдвэр | | | | | 05.12<br>05.31 | 06.21 | 07.12 | | | | | |
| 4 | Шатахуун түгээх станц, газрын тос, хийн агуулах | | | | | | | 07.20 | 08.09 | 09.01<br>09:20 | | | |
| 5 | Эрүүл мэндийн байгууллага | | | | | | | | | 09.21 | 10.11 | 11.01<br>11.20 | |
| Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт | | | | | | | | | | | | | |
| 1 | Үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт | | | | | | 06.01 | 07.10 | 08.10<br>09.10 | | | | |

Төлөвлөгөөт хяналт шалгалт - 5
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт – 1
Гүйцэтгэлийн хяналт шалгалт - 6

---oOo---

БАТЛАВ.
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН
ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН

2025 оны 01 дүгээр сарын ....-ны өдөр

## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | Хамрагдах байгууллага, барилга байгууламж | Хугацаа | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-р сар | 2-р сар | 3-р сар | 4-р сар | 5-р сар | 6-р сар | 7-р сар | 8-р сар | 9-р сар | 10-р сар | 11-р сар | 12-р сар |
| 1 | Төр, захиргааны зориулалттай барилга байгууламж | 01.05 01.23 | | 03.02 03.24 | | | | | | | | | |
| 2 | Орон сууцны барилга байгууламж */дунд төвөгшилтэй/* | | 02.02 02.24 | | 04.01 04.24 | | | | | | | | |
| 3 | Эрчим хүчний барилга байгууламж | | | | | | | | | | 09.28 10.16 | 11.16 | 12.10 |
| 4 | Рашаан, сувилал, амралтын газрын барилга байгууламж | | | | | | 06.03 06.22 | | 08.10 08.28 | | | | |
| 5 | Шатахуун түгээх станц, АХЦС-ын барилга байгууламж | | | | | | | 07.20 08.07 | | 09.01 09.20 | | | |
| 6 | Ил, далд уурхай, ашигт малтмалын боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж | | | | | 05.12 05.31 | | 06.23 07.12 | | | | | |

Төлөвлөгөөт хяналт шалгалт - 6
Гүйцэтгэлийн хяналт шалгалт - 6

---oOo---